



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 он

УУЛҮЗЭЭГҮЙ ХОРМОЙ ШУУХ...

Уул үзээгүй хормой шуух...

Банкны салбарын үзүүлэлт тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээлийн хэмжээ буурав. Оны эхнээс хугацаагүй хадгаламжид хүү тооцож эхэлсэн нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүллээ. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.


Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын өсөлтийг бууруулах үүднээс бодлогын хүүг өндөр түвшинд байлгасан нь үр дүнгээ өгч, оны сүүлд инфляцын түвшин нэг оронтой тоонд оров.

Төлбөрийн тэнцэл, тэр дундаа урсгал тэнцэл ашигтай гарсан нь валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн худалдан авах чадварыг сайжруулжээ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнтэй холбоотой төсвийн орлого нэмэгдэж, төсвийн тэнцэл ашигтай гарлаа.

Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логиستيкийн салбарын сэргэлт харьцангуй хурдан, үйлчилгээ болон худалдааны салбар өсөлттэй хэвээр байсан нь эдийн засаг 7 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүллээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж оны эхнээс хөдөө аж ахуйн салбар уналттай байсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний үнийн болон тоо, хэмжээний өсөлтөд найдан эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр төсөөлж, төсвийн орлого болон зардлын хэмжээг өндөр түвшинд баталсан нь “Уул үзээгүй хормой шуух, ус үзээгүй гутал тайлах” гэдэг шиг яаруу сандруу үйлдэл боллоо.

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2020-2023”-ийн хэрэгжилт хангалтгүй байна.



Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү олгожээ. Малчдад олгох зээлийн хэмжээ 57 орчим хувиар нэмэгдсэн бол картын зээл 9 орчим хувиар буурчээ.


Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Онолын тодорхойлолт

Банкны шинээр олгосон
зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн эцэст



Шинээр иргэдэд олгосон
зээлийн хэмжээ нэмэгдэв.

38%

2023 оны жилийн
эцсийн гүйцэтгэл

2023 ОНД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын бизнесийн зээл олголт нэмэгдэж эдийн засагт сэргэхэд чухал нөлөө үзүүлжээ.



Банкуудын зээлийн чанар сайжирчээ.



Банкуудын өөрийн хөрөнгөөр бий болгосон ашиг хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.



Системийн нөлөө бүхий таван банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа олон нийтэд амжилттай гаргахаас гадна 443 тэрбум төгрөгийг ногдол ашиг хуваарилахаар болов.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр байгаа нь банкуудын эх үүсвэр нэмэгдэхэд нөлөөллөө.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он

Бодлогын хүү өндөр байсан хэдий ч банкны салбарын зээл олголт тасралтгүй өсжээ.

Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч эдийн засгийн салбаруудад олгох зээлийн хэмжээ нэмэгдэв. ЗГ-аас ХАА-н салбарт хөнгөлөлттэй зээлийг банкуудтай хамтран хэрэгжүүлэв.

Банкны зээлийн багц


Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

Зээлийн үлдэгдэл

23%

ӨСӨВ.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо




Эдийн засгийн бүхий л салбарт зээл олголт нэмэгджээ.

Худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй зээлийн өсөлт үргэлжилж байна.

Уул уурхай, боловсруулах салбарын сэргэлт нь тус салбарт олгох зээл олголтыг нэмэгдэхэд нөлөөлжээ.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн эцэст

Тэрбум ₮



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Бизнесийн зээлийн хэмжээ

27%

НЭМЭГДЭВ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээл буурчээ.

7.5%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн салбаруудад олгох зээлийн хэмжээ нэмэгдсэн нь зээлийн чанарт нөлөөлжээ.


Иргэдийн хэрэглээний зээлийн чанаргүйдэл хэвийн түвшинд байгаа хэдий ч картын болон автомашины зээлийн чанаргүйдэл өндөр хэвээр байна.

Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа нь эдийн засгийн салбаруудын зээлийн чанаргүйдлийг буурахад нөлөөллөө.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Хадгаламжийн хүү

11.6%

Хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь хадгаламжийн хүүг нэмэгдэхэд нөлөөллөө.


Зээлийн хүү харьцангуй тогтвортой байна.



Оны эхнээс хугацаагүй хадгаламжид хүү тооцсон, хадгаламжийн хүү өссөн нь банкны эх үүсвэрийг нэмэгдүүлжээ.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой, инфляц аажмаар буурсан нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдүүлжээ. Хугацаагүй хадгаламжид хүү тооцсон нь харилцах дансны үлдэгдлийг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.

Банкны эх үүсвэр, жил бүрийн эцэст



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Банкны эх үүсвэр

27%

нэмэгджээ.

Банкны системийн долларжилт

Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын
эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгаагаар
тодорхойлогддог.

Эх үүсвэрийн долларжилт


29%

байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Төгрөгийн худалдан авах чадвар сайжирсан нь эх үүсвэрийн долларжилт буурахад нөлөөллөө.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байсан нь төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүллээ.
Инфляц аажмаар буурч байгаа үед хугацаагүй хадгаламжид хүү тооцож эхэлсэн нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдүүллээ.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


23%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 9.6 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хасбанкны актив 30 хувиар, Голомт банк болон Төрийн банкны актив 25 хувиар тус тус өсжээ.

Банкнуудын актив




Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх онтой харьцуулахад 3.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ-ны эх үүсвэр 2.5 их наяд төгрөгөөр, Голомт банкны эх үүсвэр 2.1 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банк, Хасбанк болон Төрийн банкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр



2021	2022	2023
Хаан		
2021	2022	2023
ХХБ		
2021	2022	2023
Голомт		
2021	2022	2023
Төрийн банк		
2021	2022	2023
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

13%

нэмэгджээ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл, компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж дунджаар

20%


Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20 хувь өсжээ. Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашгийн хэмжээ өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа олон нийтэд амжилттай гаргахаас гадна 443 тэрбум төгрөгийг ногдол ашиг хуваарилахаар болов.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байна.

Банкууд олон нийтэд хувьцаагаа амжилттай гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ. Банкууд эдийн засгийн өсөлтийг дэмжих, гол салбаруудын идэвхжилийг нэмэгдүүлэхэд хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкнгуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ



2021	2022	2023
Хаан		
2021	2022	2023
ХХБ		
2021	2022	2023
Голомт		
2021	2022	2023
Төрийн банк		
2021	2022	2023
Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

18.6%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд
нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий
банкуудын хөрвөх чадварын
харьцаа үзүүлэлтийн дундаж


44%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий таван банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Иргэд болон бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна.
Хасбанкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан хэдий ч хөрвөх чадвар өндөр
хэвээр байна.

Банкнудын хөрвөх чадварын харьцаа



2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

25.0 %

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2023 онд: Эдийн засгийн өсөлт 7 хувьтай гарлаа. Хил гаалийн нөхцөл байдал сайжирч, оны эхнээс уул уурхай түүнийг дагасан тээвэр, логистикийн салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ. Үйлчилгээ, худалдааны салбарын өсөлт харьцангуй тогтмол байгаа нь эдийн засгийн өсөлтийн ихэнх хэсгийг бүрдүүлжээ. Барилга болон боловсруулах салбарын сэргэлт харьцангуй удаан байна. Оны эхнээс байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байна.

Төлөв байдал: Манай улсын хувьд уул уурхайн бус салбар тэр дундаа барилга, боловсруулах болон хөдөө аж ахуйг дэмжих чиглэлээр дэд бүтцийн ажлуудыг эрчимжүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна. Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн ажлууд ашиглалтад орох, Оюу Толгойн гүний уурхайн олборлолт эрчимжиж, зэсийн баяжмал дахь агууламж нэмэгдэх нь эдийн засгийн өсөлт хадгалагдах хүлээлтийг бий болгож байна. Ирэх оны хувьд, уул уурхайн гаралтай түүхий эдийн экспортоос олох орлогыг өөдрөгөөр төсөөлж, төсвийн зардлыг 20 гаруй хувиар нэмэгдүүлсэн нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байна.


2023 оны байдлаар эдийн засаг 7 хувиар өсөв.

Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логиستيкийн салбарын сэргэлт хурдацтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлээ.

Худалдаа, үйлчилгээний салбарын тогтмол өсөлттэй байгаа нь эдийн засгийн сэргэлтэд ихээхэн эерэг нөлөө үзүүлжээ.

Боловсруулах үйлдвэр болон барилгын салбар аажмаар сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын сэргэлт удаашралтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.



Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 55 хувиар өсжээ.


Эрдэс бүтээгдэхүүн, түүний дотор нүүрс, зэсийн баяжмал, боловсруулаагүй нефтийн олборлолт нэмэгдсэн нь экспортын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлжээ. Малын гаралтай түүхий эдийн экспорт нэмэгдэж байна.

Дэлхийн зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжиж, тээвэр логиستيкийн зардал цар тахлын өмнөх үетэй ижил түвшинд хүрсэн нь импортын өсөлтийн хурд саарахад нөлөөлжээ.


Хил, гаалийн нөхцөл байдал сайжирч тээвэр, логиستيкийн хүндрэл багассан нь **экспорт** нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.



Дэлхийн зах зээл дэх бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжсон нь **импортод** нөлөөлжээ.



Экспортын нөхцөл байдал сайжирч **худалдааны тэнцэл** **ашигтай** гарлаа.





Төлбөрийн тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч төгрөгийн ханшид ирэх дарамт буурлаа.

Манай улс импортоос илүүтэйгээр экспортолсон нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүлээ.

Гадаадын хөрөнгө оруулалт бууралттай хэдий ч экспортын үйл ажиллагаа эрчимжиж, урсгал дансны алдагдал буурсан нь төлбөрийн тэнцэл ашигтай гарах нөхцөлийг бүрдүүлээ.

Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж эхэллээ.




Инфляцын өсөлтийн хурд аажмаар саарч нэг оронтой тоонд хүрлээ.

Дэлхийн зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжиж ирсэн нь нийлүүлэлтийн гаралтай инфляц буурах нөхцөлийг бий болгов. Оны эхнээс төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн нь эрэлтийн гаралтай инфляцыг өдөөв.

Дотоодын хүнс тэр дундаа мах болон гурилын үнийн өсөлт нь инфляц өндөр байхад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Инфляц болон бодит хадгаламжийн хүү

Хувиар



Төсвийн тэнцэл 763 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Оны эхнээс уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдсэн нь төсвийн орлогыг нэмэгдүүлж ашигтай гарахад нөлөөллөө.

Оны 3 дугаар улиралд төсөвт тодотгол хийсэн нь төсвийн зарлагын өсөлтийг нэмэгдүүлэв.




Сүүлийн хоёр жил үндсэн тэнцэл ашигтай гарлаа.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс
30% нэмэгджээ.

Төсвийн зарлага өмнөх оноос 20% өсжээ.

Төсвийн алдагдал буурчээ.

ДНБ-д эзлэх хувиар



“Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг батлан 2023 онд зээлийн хүүг сарын 1%-д хүргэх зорилтыг тавьсан.

1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчны бүрдүүлэх чиглэлээр – **24 арга хэмжээ**
2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр – **15 арга хэмжээ**
3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах чиглэлээр – **15 арга хэмжээ**
4. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр – **4 арга хэмжээ**

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2020-2023” хэрэгжилт 65% байна.

1.Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчны бүрдүүлэх

Биелэлт

56%

Биелээгүй

2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах

77%

3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах


63%

4. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах

63%


“Зээлийн хүүг бууруулах стратеги 2020-2023” хэрэгжилт бодитоор 5% байна.

Стратегийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт болон төсвийг тодорхой тусгаж өгөх нь цаашдын хэрэгжилтийн үнэлгээг боловсруулахад чухал нөлөөтэй болох нь харагдаж байна.




1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, макро тогтвортой орчин бүрдээгүй байна.

Төсвийн хэт тэлэлт, түүнийг дагасан төсвийн алдагдал нь хадгаламж, зээлийн хүү өндөр байхад нөлөөлж байна. Эдийн засаг сэргэж татварын орлого нэмэгдэх үед засгийн газрын үр ашиггүй зардлууд нь инфляцыг өсгөх, төгрөгийн гадаад валюттай харьцах суурь дарамтыг нэмэгдүүлж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарах шаардлага өндөр байна.




1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, макро тогтвортой орчин бүрдээгүй байна.

Төсвийн хэт тэлэлт, түүнийг дагасан төсвийн алдагдал нь хадгаламж, зээлийн хүү өндөр байхад нөлөөлж байна. Эдийн засаг сэргэж татварын орлого нэмэгдэх үед засгийн газрын үр ашиггүй зардлууд нь инфляцыг өсгөх, төгрөгийн гадаад валюттай харьцах суурь дарамтыг нэмэгдүүлж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарах шаардлага өндөр байна.




1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, макро тогтвортой орчин бүрдээгүй байна.

Төсвийн хэт тэлэлт, түүнийг дагасан төсвийн алдагдал нь хадгаламж, зээлийн хүү өндөр байхад нөлөөлж байна. Эдийн засаг сэргэж татварын орлого нэмэгдэх үед засгийн газрын үр ашиггүй зардлууд нь инфляцыг өсгөх, төгрөгийн гадаад валюттай харьцах суурь дарамтыг нэмэгдүүлж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарах шаардлага өндөр байна.



1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, макро тогтвортой орчныг бүрдүүлэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл 56% хэдий ч зээлийн эх үүсвэрийн зардал буураагүй байна.


Төсвийн хэт тэлэлт, түүнийг дагасан төсвийн алдагдал нь хадгаламж, зээлийн хүү өндөр байхад нөлөөлж байна. Эдийн засаг сэргэж татварын орлого нэмэгдэх үед засгийн газрын үр ашиггүй зардлууд нь инфляцыг өсгөх, төгрөгийн гадаад валюттай харьцах суурь дарамтыг нэмэгдүүлж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарах шаардлага өндөр байна.



2.Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний гүйцэтгэл 73% хэдий ч зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ суурь түвшинтэй ижил түвшинд байна.

Чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчинг буй болгохгүй бол зээлийн эрсдэлийн зардал буурахгүй.

Зээлийн эрсдэлийн сангийн нийт активд эзлэх хувь



3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний гүйцэтгэл 63% байгаа бол үйл ажиллагааны зардлын хэмжээ суурь оноос 5 хувиар буурчээ.

Тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгалын шимтгэл нь үйл ажиллагааны зардал нэмэгдэхэд нөлөөллөө.

Технологийн дэвшлийг ашиглах, түүний ач холбогдлыг тоон үзүүлэлтээр хэмжих хэрэгтэй байна.

Банкууд нэгдсэн байдлаар АТМ ашиглах болсноор зарим төрлийн хураамжийг бууруулжээ.

Хүүгийн бус зардлын нийт активд эзлэх хувь

